



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар сарын 30-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 246 ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 34.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ журамд албан хэрэг хөтлөлтийн бусад журам, зааврыг нийцүүлэх арга хэмжээ авах, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Архивын ерөнхий газар (С.Энхбаатар) нарт үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Х.НЯМБААТАР